

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал.....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	17
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	23
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	24
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	26

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/310
танай _____-ны № _____-т

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Ш.ЭНХТӨР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Хангамжийн материал дансны 3,674,812.1 мянган төгрөгийн үлдэгдэлд үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө, зардлаар тайлагнах зүйлсийг ангилал буруу бүртгэж санхүүгийн байдал, үр дүн, өмчийн өөрчлөлтийн тайланг буруу илэрхийлсэн.

Ажилчдын цалинг олгохдоо ажилласан ажлын хоногийг сар бүр тогтмол 22 өдрөөр тооцсоноос хоол, унааны мөнгө 31,483.6 мянган төгрөгийг илүү олгосон байна. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5 зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "үнэн зөв" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Ш.Энхтөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 28-наас 2019 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Эс Жи Эм Ди Аудит ХХК-ийн аудитын баг аудитыг хариуцаж хэрэгжүүлэв.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 130 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь Монгол Улсын хэмжээнд эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж, бүс нутагтаа анагаах ухааны ололт амжилтаар тэргүүлэгч эрүүл мэндийн байгууллага болох гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Эрүүл мэндийн сайдын тушаалаар Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсын хэмжээнд эх хүүхдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ үзүүлэх
- Эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг урт богино хугацааны мэргэшүүлэх сургалт
- Бусад эрүүл мэндийн байгууллагуудад лавлагаа, тусламж үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрүүл мэндийн тухай
- Донорын тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Эмералд” програм хангамж ашигладаг байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1.0 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон бөгөөд материаллаг байдлын суурийг нийт хөрөнгийн дүнгээс тооцоход их байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгосон.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны нийт зардал 34,390,631.5 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 343,906.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тогтоов.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 18 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 10 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөгөөр/ Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	3,984.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	31,483.6	
3	Албан шаардлага өгсөн	6	12,156,912.1	
	Дүн	10	12,192,379.7	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

Эм эмнэлгийн хэрэгслийг авахдаа сонгон шалгаруулалтад ороогүй байгууллага (Гранд мед фарм ХХК)-аас нийт 78,400.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Энэ талаар Эрүүл мэндийн яамны Эм үйлдвэрлэл технологийн газрын Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн Т.Мөнхтуулаас 2018 оны 4 сарын 16-ны өдөр цахим шуудан ирсэн ба үүнд “Эрүүл мэндийн яамны Эм эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн тендерт шалгарсан Гранд мед фарм ХХК-тай 3 удаагийн гэрээ байгуулж худалдан авалт хийсэн болно”. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 “Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Тус төв холбогдох худалдан авах үйл ажиллагаандаа сонгон шалгаруулалтад ороогүй байгууллагаас худалдан авалт хийхгүй байх, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-ийн заалтыг дагаж мөрдүүлэх, шууд гэрээ байгуулах эрх олгосон албан тушаалтанд хариуцлага тооцох, албан шаардлага өгөх,

2.8.1.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Тус төв нь ажиллагсдын цалингаа Санхүүгийн тооцоолох төвийн “Payroll” програм ашиглан олгодог. Ажилчдын цалинг олгохдоо ажилласан ажлын хоногийг сар бүр тогтмол 22 өдрөөр тооцоноос хоол, унааны мөнгө 31,483.6 мянган төгрөг илүү олгогдсон байна. Энэ нь үнэн зөв найдвартай байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Тус төв ажиллагсдын ажилласан ажлын хоногийг сар бүр тогтмол 22 өдрөөр тооцоноос хоол, унааны мөнгө 31,483.6 мянган төгрөгөөр илүү олгогдсоныг улсын орлого болгохоор төлбөрийн акт тогтоох,

2.8.1.3 Балансын данстай холбоотой асуудал

Бусад хангамжийн материал буюу ашиглалтад байгаа бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс дансанд оны эхэнд 3,222,382.7 мянган төгрөг, 2018 оны 4-р улирлын байдлаар 3,674,812.1 мянган төгрөгийн хангамжийн зүйлс бүртгэлтэй байна. Уг дансанд үндсэн

хөрөнгийн шинж чанартай болон шууд зардалд орох ёстой хангамжийн зүйлс бүртгэсэн байна. Мөн 2012 оноос хойш ажилчдад олгосон нормын хувцас, хэрэгсэл бүртгэлтэй байна.

Энэ нь иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, УСНББОУС 12-ын 12.3 заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Тус төв нь үндсэн хөрөнгө болон хангамжийн зүйлсийн ангиллыг зөв хийж байх, зардлаар хүлээн зөвшөөрөх ёстой бага үнэтэй зүйлсийг холбогдох тайлант хугацаанд бүртгэлд тусган мөрдөж ажиллах албан шаардлага өгөх,

2.8.1.4 Дотоод аудит

Тус төвийн төлбөрт үйлчилгээний бэлэн мөнгөөр хүлээж авдаг орлогын гүйлгээг тулган үзэхэд долоо хоног бүрийн баасан гаригт ажлын таван өдөрт хуримтлагдсан орлогыг харилцах дансанд тушаасан байна. Түүвэр хийж үзэхэд 6 дугаар сарын 4-нөөс 8-ны өдрийн орлого 29,005.8 мянган төгрөгийг 6 дугаар сарын 8-нд, 6 дугаар сарын 18-наас 22-ны өдрийн орлого 33,690.9 мянган төгрөгийг 6 дугаар сарын 22-нд, 8 дугаар сарын 13-наас 17-ны өдрийн орлого 41,741.6 мянган төгрөгийг 8 дугаар сарын 17-нд тус тус тушаасан байна.

Энэ нь иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Мөнгөн кассын ажиллагааны журмыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Бэлэн мөнгөний орлогыг өдөр тутам банканд тушааж байх, Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын I хавсралтын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана”, 6.1-д “Төсвийн байгууллагын кассад хэрэгцээнээс илүү мөнгө хадгалах явдлаас зайлсхийх үүднээс жижиг мөнгөн сангийн хэмжээг нарийвчлан төлөвлөж байна” гэсэн заалтуудыг дагаж мөрдөн ажиллах албан шаардлага өгөх,

2.8.1.5 Балансын данстай холбоотой асуудал

Тус төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл нь 2017 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс 14.5 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь оршин байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дүгээр зүйлийн 5.1.4 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: 2018 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийн зөрүүг холбогдох хууль, журмын дагуу тайланг үнэн зөв болгох, “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”-ын дагуу албан шаардлага хүргүүлэх.

2.8.1.6 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

Эм эмнэлгийн хэрэгслийг худалдан авах 7,866,100.0 мянган төгрөгийн сонгон шалгаруулалт хийхдээ үнэлгээний хорооны хараат бус хоёроос доошгүй гишүүн оролцуулаагүй байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцээгүй, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 “шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг дагаж мөрдөх” Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Тус төв худалдан авах үйл ажиллагаандаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47.4, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-ийн заалтыг дагаж мөрдөх тухай албан шаардлага өгөх.

2.8.1.7 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

“Эм эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулах “НТ201812010” Багц 36, 37, 39, 43, 55-т шалгарсан Нуган трейд ХХК-аас гүйцэтгэлийн баталгаа аваагүй байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 “Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээ дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээлцэх хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна”, 43.4 “Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана”, 43.4.2 “100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах”, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Тус төв худалдан авах үйл ажиллагаандаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-ийн заалтыг даган мөрдөж ажиллах талаар албан шаардлага өгөх.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төсөл хөтөлбөрт аудит хийх, худалдан авах ажиллагааг нарийвчлан шалгах, үйлдвэрчний эвлэлийн санхүүгийн тайланд аудит хийх.

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 6 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 28,380,702.9 мянган төгрөгийн төсөв

батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 28,397,022.8 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар <https://shilendans.gov.mn/> цахим системийн дагуу 5,000.0 мянган төгрөгөөс дээш эм эмийн хэрэгслийн 511 удаагийн 6,368,122.8 мянган төгрөгийн гүйлгээг, мөн бараа материал болон аж ахуйн материалын 152 удаагийн гүйлгээгээр 2,251,757.4 мянган төгрөгийн гүйлгээний мэдээллийг хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаагаатай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Менежментийн хурлын зардлын 2,190.0 мянган төгрөгийн анхан шатны баримт дутуу, хурлыг зохион байгуулаагүй.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэнэ.
- Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд зөрүүтэй мэдээлэл хүрнэ.
- Төсвийн хөрөнгө шамшигдах

1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Төслийн менежментийн хурлыг 2018 оны 12 дугаар сарын 26-наас 27-ны өдрүүдэд ЭХЭМҮТ дээр зохион байгуулсан. Холбогдох баримтыг хавсаргав.

2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

2.1 Илрүүлэлт:

“Орбис” төслийн хүрээнд аймгуудад хийгдсэн хүүхдийн нүдний үзлэгийн анхан шатны баримт дутуу, Ховд аймагт рефракцийн үзлэг хийгдээгүй учир зарцуулах ёстой 1,054.0 мянган төгрөг зарцуулаагүй.

